



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/49

Сүхбаатар сум


Г Гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээнд  
шаардлагатай зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15, 16, 17, 18, 19, 20 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны тухай" 266 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар", аймгийн Онцгой комиссын 2022 оны 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шаамар суманд шүлхий өвчин гарсантай холбогдуулан эргүүлийн пост ажиллуулах, ариутгалын бодисын нөөц бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Шаамар сумын Засаг дарга (Ф.Серикбол)-д даалгасугай.

2. Эргүүлийн пост ажиллуулах, ариутгалын бодисын нөөц бүрдүүлэхэд шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (О.Мөнхбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2022 оны 03 дугаар сарын 01-ний дотор тайлагнахыг Шаамар сумын Засаг дарга (Ф.Серикбол)-д үүрэг болгосугай.




Н. ХАГВАДОРЖ



Боловруулсан: .....  
Хянасан: .....  
Хугацаа: .....

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны  
02 дугаар сарын 09-ны өдрийн А/МЗ  
тоот захирамжийн хавсралт



ЭРГҮҮЛИЙН ПОСТ АЖИЛЛУУЛАХ, АРИУТГАЛЫН БОДИСЫН  
НӨӨЦ БҮРДҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Сум	Шаардлагатай төсөв
1	Шаамар	5,000,000

Боловсруулсан:

/Б.Мөнхжаргал/

Хянасан:

/Ж.Хишигдэлгэр

